



Дэлгэрэнгүй багц /эрэгтэй/ шинжилгээний бэлтгэл

Шээсний шинжилгээний бэлтгэл:

- Шээсний шинжилгээ өгөхөөс өмнө түрүү булчирхайн эхо хийлгэнэ. Учир давсаг шээстэй байхад давсаг, түрүү булчирхай илүү сайн харагдана.
- Шөнийн турш давсганд хуримтлагдсан өглөөний шээснээс зориулалтын ариун саванд авч 2 цагийн дотор лабораторит хүргэсэн байна.
- Зориулалтын савны тагийг зөвхөн шээх үедээ онгойлгож шээсний дунд хэсгээс савны × хүртэл (100 мл орчим) тосч аваад шууд таглана.
- Шээсний сорьцыг 2 цагаас илүү хугацаагаар хадгалсан бол устгаж, өглөөний /эхний/ шээснээс хойш 2 цаг орчим болсон бол дахин дээрх хэмжээний шээсийг зориулалтын саванд авч өгнө. Шээсний ерөнхий шинжилгээний сорьцыг хөлдөөж болохгүй.

Цусны шинжилгээний бэлтгэл:

- Өлөн байх /8–12 цагийн турш хоол идээгүй болон газтай болон чихэрлэг ундаа, зөгийн бал болон чихэртэй цай уугаагүй байх/
- 24 цагийн өмнөөс архи согтууруулах ундаа, өөх тос ихтэй хоол хэрэглээгүй байх, биеийн хүчний дасгал болон хэт ачаалал аваагүй байвал илүү тохиромжтой.
- Цусны шинжилгээ өгөхөөс өмнө 15 минут орчим тайван суух хэрэгтэй.
- Цус өгөхийн өмнө эхо, дуран, рентген зэрэг шинжилгээнд багажийн шинжилгээнд ороогүй, судсаар тодосгогч бодис хэрэглээгүй байна.

Зүрхний бичлэг хийлгэхээс өмнө шатаар дээш доош хурдан алхаагүй, гүйгээгүй байх ба хэрвээ ямар нэгэн ачаалал авсан бол 5–10 минут орчим тайван сууна.

Ясны сийрэгжилтийн шинжилгээ:

- Хөлийн өсгий ясанд хийгддэг учир тирко өмсөхгүй, тайлахад хялбар байхаар оймс өмсөж ирнэ үү.

Хэвлийн эхо: Өлөн байх

Мазок болон түрүү булчирхайн эхо:

- Давсганд шээстэй байвал илүү тохиоромжтой
- Өмнөх өдөр нь бэлгийн харьцаанд ороогүй байх

Дурангийн шинжилгээний ерөнхий заавар:

- Шинжилгээний цагаас 30 минутын өмнө ирнэ.
- Бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээний өмнө зориулалтын туулгыг зааврын дагуу ууж гэдсийг гүйцэд цэвэрлэсэн байна.
- Ходоод болон бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээ анестезиологи эмчийн хяналтан дор судасны унтуулгатай хийгдэнэ.
- Унтуулгын бодисын үйлчилгээ бүрэн гартал 2 цаг орчим сэрээх өрөөнд хянана.
- Тухайн өдөр сэрэмжүүлэх үүднээс машин барихыг хориглох тул та дагалдах хүний хамт ирвэл зохимжтой.

Ходоодны дурангийн шинжилгээний бэлтгэл:

- Урд орой 19 цагаас хойш хоол идээгүй байх
- Өглөө хоол идээгүй, ус уугаагүй байх
- Ходоод дурандах явцад хеликобактерийн шинжилгээг авна.
- Ходоодны дуранг хийсний дараа шууд бүдүүн гэдэсний дуран үргэлжилнэ.